



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2018 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 01

Мандалговь

Хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 31 дүгээр зүйл, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2.2.е, 3.4, 4 дүгээр заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. “Дундговь-Ус” орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 177,380,211.00 /Нэг зуун далан долоон сая гурван зуун наян мянга хоёр зуун арван нэг төгрөг/-ний анхны өртөгтэй, 125,785,539.13 /Нэг зуун хорин таван сая долоон зуун наян таван мянга таван зуун гучин есөн төгрөг арван гурван мөнгө/-ний хуримтлагдсан элэгдэл бүхий 6 нэр төрлийн 51,594,671.87 /Тавин нэгэн сая таван зуун ерэн дөрвөн мянга зургаан зуун далан нэгэн төгрөг наян долоон мөнгө/-ний үлдэгдэл өртөг бүхий үндсэн хөрөнгийг Хот тохижуулах орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг зохих хууль журмын дагуу байгууллагын данс бүртгэлээс хасахыг “Дундговь-Ус” ОНӨҮГ /Д.Ганбаатар/-т, бүртгэж авахыг Хот тохижуулах орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт тус тус даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 14 дүгээр тогтоолын 3 дахь заалтыг хүчингүй болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцэцэжид үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРҮҮЛЭГЧДИЙН
 2018-НЫ 01 САРЫН 2-ӨДРИЙН
 ... ДУГААР ТОГООЛЫН ХАВСРАЛТ

Балансаас балансад шилжүүлэх үндсэн хөрөнгө

| № | Үндсэн хөрөнгө, тээврийн хэрэгслийн нэр | Ашиглах хугацаа /жил/ | Ашиглалтанд орсон огноо | Анхны өртөг | Хөрөнгийн тоо | Тооцсон элэгдэл | Үлдэг өртөг |
|---|---|-----------------------|-------------------------|----------------|---------------|-----------------|---------------|
| 1 | Гражийн барилга | 40 | 1992.01.01 | 90,035,000.00 | 1 | 41,846,133.40 | 48,188,866.60 |
| 2 | Гражийн зуухны барилга | 40 | 1992.01.01 | 6,286,080.00 | 1 | 2,880,274.73 | 3,405,805.27 |
| 3 | Гражийн хашаа | 8 | 1990.01.01 | 2,538,400.00 | 1 | 2,538,400.00 | 0 |
| 4 | Хогийн машин 76-44 ДУА | 6 | 2010.10.01 | 32,919,000.00 | 1 | 32,919,000.00 | 0 |
| 5 | Хогийн машин 39-08 ДУА | 8 | 2006.01.01 | 43,914,531.00 | 1 | 43,914,531.00 | 0 |
| 6 | Нам даралтын тогоо 0,6 | 50 | 2006.01.01 | 1,687,200.00 | 1 | 1,687,200.00 | 0 |
| 7 | ДҮН | | | 177,380,211.00 | 6 | 125,785,539.13 | 51,594,671.87 |